

БАТЛАВ.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
 БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
 Д.БАТЧУЛУУН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ, ОРОЛЦОО,
 ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
 АЖЛЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.03.09

Дархан

Д/ д	Хийгдэх үйл ажиллагаа	Хугацаа	Зохион байгуулах хэлтэс, мэргэжилтэ н	Хүрэн үр дүн
1	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлиг, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дэх хэсэгт “Өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь нийт ажлын байрныхаа 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуулах” гэж заасан болон уг хувь хэмжээнд хүргэх ажлыг хэрэгжүүлж ажиллах	Жилдээ	БХБХэлтэс	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. Хамрах хүрээ: ГЗБГЗЗ Газрын харьяа байгууллагууд Хөгжлийн бэрхшээлтэй 1 хүнийг авч ажиллуулсан байна.
2	Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламжид захиалагчийн техник хяналтыг гүйцэтгэхэд батлагдсан зураг төслийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангуулах арга хэмжээг авч ажиллах	II улирал, IV улирал	БХБХэлтэс	Захилагчийн хяналтын тоо, Бүх барилга байгууламж эх зураг төслийн дагуу баригдсан байна.
3	Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулан ажиллуулах чадавхижуулах сургалтыг зохион байгуулах, энэ чиглэлийн мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийх	II улирал, IV улирал	БХБХэлтэс	Комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан болон сургалтад хамрагдсан иргэдийн тоо, Улсын хэмжээнд 21-ээс доошгүй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг оролцуулсан байна.
4	Аймгийн төвүүд дэх олон нийтийн зориулалттай барилга байгууламжуудад хийсэн үзлэг, үнэлгээнд үндэслэн тэдгээрт хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлэх, саадгүй зорчих орон зай, орчныг бүрдүүлэн тохижуулах (зориулалтын тоноглол, тоног төхөөрөмжийг суурилуулах, зам талбай, зогсоолыг хийх, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах гэх мэт) ажлыг зохион байгуулах	II улирал, IV улирал	БХБХэлтэс	Үзлэг хийсэн, хүртээмжийг нэмэгдүүлсэн барилга байгууламжийн тоо (аймаг бүрт 3-аас доошгүй барилга байгууламж, гадна орчны хүртээмжийг сайжруулсан байна.)
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн төлөвлөлтийн чиглэлээр архитекторуудад зориулсан сургалтанд хамрагдсан байх	II улирал, IV улирал	БХБХэлтэс	Дэд бүтцийн төлөвлөлтийн чиглэлээр норм, стандарт, хот байгуулалтын баримт бичгийг судалж, нэмэлт өөрчлөлт оруулах асуудалд санал өгөх, Архитекторуудын



				хүрээнд: Салбарын хэмжээнд зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсан байна.
6	Иргэдэд үйлчлэх "Нэг цэгийн үйлчилгээ" "Нэг цонхны үйлчилгээ" болон салбарын чиглэлийн бусад үйлчилгээ үзүүлдэг газруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ бүхий тусгай цонх бий болгох, нэгдсэн үйлчилгээгүй газруудад дугаар харгалзахгүй үйлчлэх нөхцөл бололцоогоор хангах. E-gazar.gov.mn-ийг олон нийтэд таниулан, сурталчлах зорилгоор сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэлээр видео мэдээ бэлтгэх	II улирал, IV улирал	ГҮХэлтэс	Төрийн байгууллагуудын байр ашиглалтын захиргаа болон Нийтлэг үйлчилгээний газруудад шаардлагыг хүргүүлж хамтран ажилласан байна. /иргэдэд үзүүлэх үйлчилгээ стандартын шаардлагад нийцсэн байна/
7	Төрийн албан хаагчдын гэр бүлд хөгжлийн бэрхшээлтэй гишүүн байдаг эсэх талаар судалж зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Захиргаа	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэх, ажиллах нийгмийн баталгааг хангах чиглэлээр арга хэмжээ авсан байна.
8	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, албан хаагчийн олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах	Жилдээ	Захиргаа, БХБХэлтэс	Сургалт, мэдээллийн тоо хэмжээ, /Мэдээллээр хангах, сургалт сурталчилгаа хийсэн байна, Салбарын хэмжээн дэх төрийн албан хаагчид
9	Орон сууцны барилга, хотхон, хороолол барих хөрөнгө оруулагч, захиалагчдад газар, дэд бүтцийн бусад асуудыг хөнгөлөлттэй нөхцлөөр шийдвэрлэн өгч, баригдсан орон сууцны нийт талбайн 2,0 хувийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэн авахаар замаар орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх арга хэмжээ авч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэргүүн ээлжинд хамруулах	Жилдээ	БХБХэлтэс	ХБИ-ийг түрээсийн орон сууцанд хамруулсан байна. /хэмжих нэгж: Хамруулсан ХБИ-тоо, талбайн хэмжээ/
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах, барилын зураг төсөлд холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусган хэрэгжүүлэх, нийтийн зориулалттай барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй эсэхд нэгдсэн үзлэг хийж, орц, гарц болон дэд бүтцийг ХБИ-ийн эрх ашиг, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах, үр дүнг тайлагнах	Жилдээ	БХБХэлтэс	Нийтийн зориулалттай барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй эсэхд нэгдсэн үзлэг хийж, ХБИ-ийн эрх ашиг, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулсан, тайланг хүргүүлсэн байна.

Боловсруулсан:
ЗХАХМэргэжилтэн: /Б.Золбаясах/


